

Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан
зардлыг нөхөн төлөх тухай
ГЭРЭЭ

20 ~~17~~ оны ~~09~~ дугаар
сарын ~~22~~-ны өдөр

дугаар ХАЗ-20~~17~~...../...../.....

Улаанбаатар
хот

Ерөнхий зүйл

Нэг талаас Ашигт малтмал, Газрын тосны газар /цаашид Агентлаг гэх/, нөгөө талаас ашигт малтмалын ордын MV-017482 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Улсын бүртгэлийн албанд бүртгэлтэй 9011033112 тоот гэрчилгээ, 5095719 тоот регистрийн дугаартай "Товь мастер" ХХК /цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх/ нь Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр хийсэн Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутагт орших Базальтын хайлуур жоншны ордын талбайд хийгдсэн эрэл, эрэл-үнэлгээ, нарийвчилсан хайгуулын ажлын зардлуудыг улсын төсөвт эргүүлэн нөхөн төлөх нөхцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий эрэл, урьдчилсан хайгуул, нарийвчилсан хайгуул,
гидрогеологийн хайгуул, зураглалын ажлын зардлын нийт хэмжээ

1.1 Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутагт орших Базальтын хайлуур жоншны ордын MV-017482 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд улсын төсвөөс анхны зардалд 293,614.16 төгрөгийн зардал гарсан бөгөөд ноогдох хэмжээг Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу тооцоход 222,130,122.57(хоёр зуун хорин хоёр сая нэг зуун гучин мянга, нэг зуун хорин хоёр төгрөг тавин долоон мөнгө) болж байгааг хоёр тал харилцан хүлээн зөвшөөрөв.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх хүлээх үүрэг

2.1 Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан зардлыг 3 жилийн хугацаанд төлөх бөгөөд төлбөрийг төгрөгөөр төлнө.

2018 оны 2-р улиралд 74,000,000 (далан дөрвөн сая)

2019 оны 3 дугаар улиралд 74,065,061 (далан дөрвөн сая жаран таван мянга жаран нэг төгрөг)

2020 оны 3 дугаар улиралд 74,065,06,57 (далан дөрвөн сая жаран таван мянга жаран нэг төгрөг тавин долоон мөнгө)

(тоогоор)

(үсгээр)

2.2 Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2.1-т дурьдсан хугацаанд төлөхөөр хуваарилсан төлбөрийг хавсралт 1-д заасан хугацаанд Төрийн сан банкны төгрөгийн 100900000722 тоот Ашигт малтмал, газрын тосны газрын Нөхөн төлбөрийн дансанд төлнө. Төлбөр төлөхдөө гүйлгээний утга хэсэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар, хэдэн оны, хэд дүгээр улирлын төлбөр болохыг тодорхой бичнэ.

2.3 Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр төлсний дараа уг төлбөр Ашигт малтмал, газрын тосны газрын Нөхөн төлбөрийн дансанд орсон эсэхийг шалгаж болно.

2.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөхөн төлбөрийг төлөхдөө хуваарилсан үлдэгдэлтэй улиралдаа багтаан боломжит нөхцлөөр төлөлт хийж болно.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN
№ХАЗ- 20~~17~~...../...../..... гэрээ

2.5 Нөхөн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй бөгөөд төлбөрөө бүрэн төлсөн тохиолдолд төлбөрийн баримтыг Агентлагт ирүүлж, гэрээний хавсралтад гэрээ хариуцсан мэргэжилтнээр тэмдэглэл хийлгэн баталгаажуулна.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2.1 дэхь хэсэгт заасан хугацаанд төлбөрөө улиралдаа багтаан төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд тухайн улиралд төлбөл зохих төлбөрийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.

2.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээний хэрэгжилттэй холбогдсон аливаа асуудлаар Агентлагт бичгээр хүсэлт гаргаж болох бөгөөд Агентлаг нь 30 хоногийн дотор хариу ирүүлнэ.

Гурав. Ашигт малтмал, газрын тосны газрын эрх, хүлээх үүрэг

3.1. Агентлаг энэхүү гэрээний хэрэгжилттэй холбогдуулан Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардлагатай бүхий л мэдээллийг авна.

3.2 Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилтийг хангах асуудлаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчид дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.

3.3 Гэрээний хэрэгжилттэй холбоотой нөхөн төлбөр төлөхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах,

3.4 Энэхүү гэрээний 1.1-д заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд өөрийн санаачилгаараа өөрчлөхгүй байх.

3.5 Нөхөн төлбөр хийсэн хугацааг банкинд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.

3.6 Нөхөн төлбөр төлсөн баримт бичигтэй танилцан төлбөрийн хэмжээ үнэн зөв төлсөн эсэхийг Агентлагийн санхүүгийн хуулгатай тулган, гэрээний хавсралтад төлбөр төлсөн талаар тухай бүр тэмдэглэл үйлдэж баталгаажуулна.

3.7 Нөхөн төлбөрийн гэрээ байгуулахад:

a. Ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан нөхөн төлбөрийн төлөх хугацааг ТЭЗҮ, уулын ажлын тайлан болон төлөвлөгөөнд тулгуурлан АМГТГ-ын Уул уурхайн үйлдвэрлэл технологийн хэлтэс,

b. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардалд ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан нөхөн төлбөрийн тооцоололыг АМГТГ-ын Геологи хайгуулын хэлтэс,

c. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардалыг нөхөн төлөх гэрээ боловсруулах, нөхөн төлбөрийн хуваарь гаргах, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавихыг Хууль, эрх зүйн хэлтэс тус тус хариуцана.

Дөрөв. Хариуцлага, маргаан шийдвэрлэх

4.1 Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдол Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн төлбөр төлөх тухай мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.7-д заасан нөхөн төлбөр, алдангийг төлөх, төлөөгүй бол тусгай зөвшөөрлийг цуцалж, тухайн тусгай зөвшөөрлийн талбайд сонгон шалгаруулалтийг зарлана.

4.2 Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой аливаа маргаан гарсан тохиолдолд талууд маргааныг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд талууд маргааныг шийдвэрлэх зорилгоор саналаа бичгээр нөгөө талдаа хүргүүлснээс хойш ажлын 30 хоногийн дотор маргааныг шийдвэрлэх боломжтой талаар санал нэгдээгүй бол Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.3 Аж ахуйн нэгж нь энэхүү гэрээний заалтыг биелүүлээгүй тохиолдолд Агентлаг нь шүүхэд хандаж болох бөгөөд шүүх ажиллагаатай холбогдон гарах зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцана.

Тав. Гэрээ хүчин төгөлдөр болох, гэрээний хугацаа

5.1. Агентлаг болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарагдаж баталгаажсанаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.

5.2. Энэхүү гэрээний 2.1 дэхь заалтын биелэлтийг Агентлаг болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид хамтран дүгнэж акт үйлдэж гэрээг дуусгавар болгоно.

5.3. Гэрээг Монгол хэл дээр, гурван хувь үйлэх бөгөөд нэг хувийг **Мэргэжлийн хяналтын ерөнхий газар**, нэг хувийг **Ашигт малтмал, газрын тосны газар /ХЭЗХ/**, нэг хувийг ашигт малтмалын ордын **тусгай зөвшөөрөл эзэмшигч** тус тус хадгална. Гэрээний хувиуд нэгэн адил хүчин төгөлдөр байна. Гэрээ 3 хуудас, хавсралт 1 хуудас, нийт 4 хуудастай.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

6.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд уг нөхцлөөс шалтгаалан үүргээ биелүүлээгүй талыг буруутай гэж үзэхгүй.

6.2 Энэхүү гэрээний 5.1-д заасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд талууд даруй харилцан мэдэгдэж шийдвэрдэх арга замыг тодорхойлно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ашигт малтмал, газрын тосны газрыг төлөөлж:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА..... Ж. БАТМАГНАЙ

ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
..... М. БАТБАЯР

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д. ХАНГАЙ


ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН: ХЭЗХ-ИЙН
МЭРГЭЖИЛТЭН..... Б. БОЛОРЦЭЦЭГ

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай-3,
E-mail: info@mram.gov.mn
Факс: 31-03-70
Утас: 263922

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

"ГОВЬ МАСТЕР" ХХК-НИЙ ЗАХИРАЛ
..... М. ДАВААЖАВ

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р
хороо, "Сөүл бизнес центр" 404 тоот
Утас: 88880567, 88080789



2018 онд

| Улирлууд | Төлбөл зохих төлбөр /төгрөг/ | Төлбөр хийсэн он сар өдөр | Төлсөн нь | бусад тэмдэглэл |
|----------|------------------------------|---------------------------|-----------|-----------------|
| 1 | | | | |
| 2 | 74,000,000 | | | |
| 3 | | | | |
| 4 | | | | |

2019 онд

| Улирлууд | Төлбөл зохих төлбөр /төгрөг/ | Төлбөр хийсэн он сар өдөр | Төлсөн нь | бусад тэмдэглэл |
|----------|------------------------------|---------------------------|-----------|-----------------|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | 74,065,061 | | | |
| 4 | | | | |

2020 онд

| Улирлууд | Төлбөл зохих төлбөр /төгрөг/ | Төлбөр хийсэн он сар өдөр | Төлсөн нь | бусад тэмдэглэл |
|----------|------------------------------|---------------------------|-----------|-----------------|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | 74,065,06,57 | | | |
| 4 | | | | |